



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/71

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 20 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, сүм хийдийн болон бусад хурал, цуглаан, үзэсгэлэн худалдаа, караоке, аялал зугаалгын арга хэмжээ зохион байгуулахыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд хориглосугай.

2. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа иргэдийн PCR шинжилгээг сайтар нягтлан 72 цаг өнгөрсөн, шинжилгээний хариу [www.eruul.gerege.mn](http://www.eruul.gerege.mn) цахим сайтад хүлээлгийн горимд байгаа гэсэн өгүүлэмжтэй иргэдийг нэвтрүүлэхгүй байх, тухайн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа уул, уурхайн аж, ахуйн нэгжүүдийн ажилчдын ээлж солигдох үед голомтот бүсээс ирж байгаа ажилчдыг сүүлийн 72 цагийн дотор PCR шинжилгээнд хамрагдсан эсэхийг шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулж нэвтрүүлэх, 7 дахь хоногт давтан коронавирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн болон PCR шинжилгээнд хамруулах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

481210177

4. Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрээр зорчих хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс нээж байгаатай холбогдуулан голомтот бүс нутгаас ирж буй иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч бүртгэн харьяа өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад гэр бүлийн гишүүдийн хамт 7 хоногийн гэрийн ажиглалтад байлгаж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (А.Мөнхтуяа), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Сургууль, цэцэрлэг, дотуур байранд байрлаж буй тусгаарлах байрыг буулгаж, ариутгал халдваргүйтгэлийг хийж, тусгаарлах байрыг шинээр сонгож бэлэн байдлыг хангуулахыг ажлын хэсгийн дарга (А.Нарантуяа), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Голомтот бүс нутгаас ирж байгаа иргэдээс түргэвчилсэн шинжилгээ авах цэгийг шинээр Сайнцагаан сумын автотээврийн шалган нэвтрүүлэх постын дэргэд байгуулж, иргэдэд түргэн шуурхай үйлчилж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), Цагдаагийн газар (Г.Наранбаатар) нарт үүрэг болгосугай.

8. Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар 05,А/12 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж, иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт үүрэг болгосугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүрт нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ